

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын хураангуй  
тайлан

Аудитын код: **ӨВА-2026/150/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум  
2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас:70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren.p.audit@gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас:70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас:99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас:94422277 Цахим хаяг: sosorburampurev3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

Дддб. Од. 09 № 86-  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НАРИЙНТЭЭЛ СУМЫН БАЯНТЭЭГ  
БАГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ЧИМЭГМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Цэцэрлэгийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр цэцэрлэгийн барилгын засвар өргөтгөлийн ажлыг 97.1 сая төгрөгөөр гүйцэтгэж барилга байгууламжийн үнийн дүнг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Жилийн эцсээр 34.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.Тайлант онд 7 хөтөлбөр арга хэмжээнд 294.9 сая төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 91.3 хувьтай байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд улсын төсвөөс 269.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 23.7 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 4.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

6225025198

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

### Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт төсөл, 30 арга хэмжээ төлөвлөж 70.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>82,992,853.10</b>  | <b>61,817,376.58</b>  |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | 59,907,410.69         | 34,257,975.61         |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                                     | 59,907,410.69         | 34,257,975.61         |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>   | 59,907,410.69         | 34,257,975.61         |
| 31211       | Төрийн сангийн харилцах   | 59,907,410.69         | 34,257,975.61         |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | 228,294.41            | 168,283.97            |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 228,294.41            | 168,283.97            |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 22,857,148.00         | 27,391,117.00         |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>   | 8,927,500.00          | 9,993,100.00          |
| 35110       | Тусгай зориулалттай материал  | 8,927,500.00          | 9,993,100.00          |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 13,929,648.00         | 17,398,017.00         |
| 35420       | Аж ахуйн материал   | 8,173,160.00          | 10,587,510.00         |
| 35460       | Хүнсний материал  | 5,671,388.00          | 6,725,407.00          |
| 35470       | Бусад хангамжийн материал   | 85,100.00             | 85,100.00             |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>146,609,244.65</b> | <b>242,314,365.85</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 146,609,244.65        | 242,314,365.85        |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 143,113,244.65        | 238,998,365.85        |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 156,984,736.07        | 254,133,136.07        |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | (31,720,246.56)       | (41,042,069.76)       |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 22,817,243.50         | 18,120,243.50         |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | (17,407,925.65)       | (10,925,094.56)       |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 21,025,938.83         | 28,396,938.83         |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | (14,506,134.50)       | (13,823,254.47)       |
| 39209       | Зам, гүүрийн байгууламж   | 17,516,000.00         | 17,516,000.00         |
| 39210       | Хуримтлагдсан элэгдэл   | (12,468,167.04)       | (14,249,333.76)       |
| 39217       | Ном   | 871,800.00            | 871,800.00            |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 3,496,000.00          | 3,316,000.00          |
| 39301       | Програм хангамж   | 950,000.00            | 950,000.00            |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | (410,000.00)          | (590,000.00)          |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 2,956,000.00          | 2,956,000.00          |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>   | <b>229,602,097.75</b> | <b>304,131,742.43</b> |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>229,602,097.75</b> | <b>304,131,742.43</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 229,602,097.75        | 304,131,742.43        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 39,807,630.00         | 39,807,630.00         |
| 51101       | Өмч: - төрийн   | 39,807,630.00         | 39,807,630.00         |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 53,493,770.15         | 128,023,414.83        |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 28,432,722.91         | 53,493,770.15         |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | 25,061,047.24         | 74,529,644.68         |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 136,300,697.60        | 136,300,697.60        |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                            | <b>229,602,097.75</b> | <b>304,131,742.43</b> |

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>  | <b>281,458,300.00</b> | <b>403,907,400.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>24,077,500.00</b>  | <b>110,818,400.00</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | <b>24,077,500.00</b>  | <b>110,818,400.00</b> |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 19,980,000.00         | -                     |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 19,980,000.00         | -                     |
| 120017      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                          | 4,097,500.00          | 110,818,400.00        |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>257,380,800.00</b> | <b>293,089,000.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | <b>235,534,800.00</b> | <b>269,343,700.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 235,534,800.00        | 269,343,700.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                       | <b>21,846,000.00</b>  | <b>23,745,300.00</b>  |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/         | 21,846,000.00         | 23,745,300.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>256,397,252.76</b> | <b>329,377,755.32</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>256,397,252.76</b> | <b>329,377,755.32</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                      | <b>252,352,829.76</b> | <b>324,502,925.32</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                    | <b>183,507,580.23</b> | <b>245,423,588.83</b> |
| 210101      | Үндсэн цалин  | 129,661,138.78        | 153,454,392.30        |
| 210102      | Нэмэгдэл  | 46,643,772.52         | 83,744,964.68         |
| 210104      | Урамшуулал  | 7,202,668.93          | 8,224,231.85          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | <b>21,860,448.85</b>  | <b>29,906,226.69</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 15,275,093.68         | 20,362,888.67         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 1,786,869.41          | 2,388,656.38          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 1,049,110.45          | 1,200,353.19          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 729,251.47            | 1,192,065.69          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 3,020,123.84          | 4,762,262.76          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                            | <b>11,895,077.00</b>  | <b>11,960,920.00</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,523,717.00          | 1,198,430.00          |
| 210302      | Түлш, халаалт   | 10,109,760.00         | 10,282,490.00         |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 261,600.00            | 480,000.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                     | <b>1,087,730.00</b>   | <b>24,500.00</b>      |
| 210408      | Бараа материал акталсны зардал  | 1,087,730.00          | 24,500.00             |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>8,599,252.00</b>   | <b>9,475,221.00</b>   |
| 210502      | Хоол, хүнс  | 8,599,252.00          | 9,475,221.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | <b>1,925,900.00</b>   | <b>3,930,500.00</b>   |
| 210604      | Урсгал засвар   | 1,925,900.00          | 3,930,500.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | <b>935,000.00</b>     | <b>1,040,000.00</b>   |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 935,000.00            | 1,040,000.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | <b>22,541,841.68</b>  | <b>22,741,968.80</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 6,775,200.00          | 5,850,940.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 2,841,600.00          | 1,777,750.00          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол  | 12,925,041.68         | 15,113,278.80         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>4,044,423.00</b>   | <b>4,874,830.00</b>   |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | <b>4,044,423.00</b>   | <b>4,874,830.00</b>   |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 4,044,423.00          | 4,874,830.00          |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>   | <b>25,061,047.24</b>  | <b>74,529,644.68</b>  |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН</b>  | <b>25,061,047.24</b>  | <b>74,529,644.68</b>  |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>                           | <b>257,380,800.00</b> | <b>293,089,000.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>257,380,800.00</b> | <b>293,089,000.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 235,534,800.00        | 269,343,700.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 235,534,800.00        | 269,343,700.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 21,846,000.00         | 23,745,300.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,846,000.00         | 23,745,300.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                            | <b>248,529,998.66</b> | <b>318,738,435.08</b> |

|             |   |                       |                        |
|-------------|---|-----------------------|------------------------|
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>248,529,998.66</b> | <b>318,738,435.08</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                      | <b>244,485,575.66</b> | <b>313,863,605.08</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                    | 184,420,525.40        | 245,423,588.83         |
| 210101      | Үндсэн цалин  | 130,574,083.95        | 153,454,392.30         |
| 210102      | Нэмэгдэл  | 46,643,772.52         | 83,744,964.68          |
| 210104      | Урамшуулал  | 7,202,668.93          | 8,224,231.85           |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | 22,088,743.26         | 29,846,216.25          |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 15,503,388.09         | 20,302,878.23          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 1,786,869.41          | 2,388,656.38           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 1,049,110.45          | 1,200,353.19           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 729,251.47            | 1,192,065.69           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 3,020,123.84          | 4,762,262.76           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                            | 11,895,077.00         | 11,960,920.00          |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,523,717.00          | 1,198,430.00           |
| 210302      | Түлш, халаалт   | 10,109,760.00         | 10,282,490.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 261,600.00            | 480,000.00             |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 8,693,130.00          | 10,529,240.00          |
| 210502      | Хоол, хүнс  | 8,693,130.00          | 10,529,240.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | 5,906,500.00          | 6,909,550.00           |
| 210604      | Урсгал засвар   | 5,906,500.00          | 6,909,550.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 935,000.00            | 1,040,000.00           |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 935,000.00            | 1,040,000.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 10,546,600.00         | 8,154,090.00           |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 7,670,000.00          | 6,376,340.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 2,876,600.00          | 1,777,750.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>4,044,423.00</b>   | <b>4,874,830.00</b>    |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | 4,044,423.00          | 4,874,830.00           |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 4,044,423.00          | 4,874,830.00           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                 | <b>8,850,801.34</b>   | <b>(25,649,435.08)</b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  | 8,850,801.34          | (25,649,435.08)        |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                     | 51,056,609.35         | 59,907,410.69          |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                    | 59,907,410.69         | 34,257,975.61          |

## 2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл   | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 28,432,722.91     | 204,541,050.51                          |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 28,432,722.91     | 204,541,050.51                          |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | -                               | -                     | 25,061,047.24     | 25,061,047.24                           |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 53,493,770.15     | 229,602,097.75                          |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл   | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 53,493,770.15     | 229,602,097.75                          |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 53,493,770.15     | 229,602,097.75                          |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | -                               | -                     | 74,529,644.68     | 74,529,644.68                           |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 39,807,630.00                   | 136,300,697.60        | 128,023,414.83    | 304,131,742.43                          |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |                |                |        |
|-----------------------|---|-----------------------|----------------|----------------|--------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      | Зөрүү          | хувь   |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл        |                       |                |                |        |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                       | 346,832,700.00        | 318,738,435.08 | 28,094,264.92  | 91.90  |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ   | 346,832,700.00        | 318,738,435.08 | 28,094,264.92  | 91.90  |
| 210                   | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                         | 346,832,700.00        | 313,863,605.08 | 32,969,094.92  | 90.49  |
| 2101                  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                       | 261,638,600.00        | 245,423,588.83 | 16,215,011.17  | 93.80  |
| 210101                | Үндсэн цалин  | 161,148,500.00        | 153,454,392.30 | 7,694,107.70   | 95.23  |
| 210102                | Нэмэгдэл  | 94,074,200.00         | 83,744,964.68  | 10,329,235.32  | 89.02  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                   |                       |                | -              |        |
| 210104                | Урамшуулал  | 6,415,900.00          | 8,224,231.85   | (1,808,331.85) | 128.19 |
| 2102                  | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл          | 32,543,100.00         | 29,846,216.25  | 2,696,883.75   | 91.71  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                      | 22,077,600.00         | 20,302,878.23  | 1,774,721.77   | 91.96  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                      | 2,616,400.00          | 2,388,656.38   | 227,743.62     | 91.30  |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                       | 1,308,200.00          | 1,200,353.19   | 107,846.81     | 91.76  |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                    | 1,308,200.00          | 1,192,065.69   | 116,134.31     | 91.12  |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                   | 5,232,700.00          | 4,762,262.76   | 470,437.24     | 91.01  |
| 2103                  | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал               | 16,639,000.00         | 11,960,920.00  | 4,678,080.00   | 71.88  |
| 210301                | Гэрэл, цахилгаан  | 2,969,000.00          | 1,198,430.00   | 1,770,570.00   | 40.36  |
| 210302                | Түлш, халаалт   | 13,190,000.00         | 10,282,490.00  | 2,907,510.00   | 77.96  |
| 210303                | Цэвэр, бохир ус   | 480,000.00            | 480,000.00     | -              | 100.00 |
| 2105                  | Нормативт зардал  | 19,580,800.00         | 10,529,240.00  | 9,051,560.00   | 53.77  |
| 210502                | Хоол, хүнс  | 19,580,800.00         | 10,529,240.00  | 9,051,560.00   | 53.77  |
| 2106                  | Эд хогшил, урсгал засварын зардал                       | 7,106,300.00          | 6,909,550.00   | 196,750.00     | 97.23  |
| 210604                | Урсгал засвар   | 7,106,300.00          | 6,909,550.00   | 196,750.00     | 97.23  |
| 2108                  | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам | 1,063,300.00          | 1,040,000.00   | 23,300.00      | 97.81  |
| 210806                | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                         | 1,063,300.00          | 1,040,000.00   | 23,300.00      | 97.81  |
| 2109                  | Бараа үйлчилгээний бусад зардал                         | 8,261,600.00          | 8,154,090.00   | 107,510.00     | 98.70  |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                         | 6,441,800.00          | 6,376,340.00   | 65,460.00      | 98.98  |
| 210902                | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                       | 1,819,800.00          | 1,777,750.00   | 42,050.00      | 97.69  |
| 213                   | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | -                     | 4,874,830.00   |                |        |
| 2131                  | Засгийн газрын урсгал шилжүүлэг                         | -                     | 4,874,830.00   |                |        |
| 213101                | Засгийн газрын дотоод шилжүүлэг                         | -                     | 4,874,830.00   |                |        |
| 4                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл        |                       |                | 59,907,410.69  |        |
| 5                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл       |                       |                | 34,257,975.61  |        |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,360.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 1,360.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн

1. Санхүүгийн тайланд бараа материалын өмнөх оны үлдэгдэл 1,360.820 төгрөгийг шууд зардалд бичсэнийг, бараа материалын үлдэгдлээр тайлагнаж залруулав.

ӨВА-2026/150/НА-СТА-ТШЗ

Аудитаар 3 зөрчил<sup>1</sup> илэрч 3 албан шаардлага өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

### 3.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Б/21 тоот тушаалаар няравт 1,105.0 мянган төгрөг, нягтлан бодогчид 1,247.2 мянган төгрөгийн 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,352.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

2.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын шимтгэлд 168.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

3.Илрүүлэлт:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хүүхдийн хоолны материалыг их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн 1,138,570 төгрөгийн хүнсний материал, ногоо хадгалах зоорины тог удаан хугацаагаар тасарснаас шалтгаалж эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон хүнсний ногоог Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/05 тушаалаар акталсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхгүй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

### 3.3 Зөвлөмж

Зөвлөмж бичигдээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга  | Нийт алдаа |         | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |         | /мянган төгрөгөөр/ |   |              |   | Зөвлөмж |     |
|--|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|--------------------|---|--------------|---|---------|-----|
|  |            |         |                                   |     |                          |         | Үүнээс             |   |              |   |         |     |
|  | Тоо        | Дүн     | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн     | Залруулсан         |   | Залруулаагүй |   | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайланд бараа материалын өмнөх оны үлдэгдэл 1,360.820 төгрөгийг шууд зардалд бичсэнийг, бараа материалын үлдэгдлээр тайлагнаж залруулав | 1          | 1,360.8 |                                   |     | 1                        | 1,360.8 |                    |   |              |   |         |     |
| Дүн  | 1          | 1,360.8 | 0                                 | 0   | 1                        | 1,360.8 | 0                  | 0 | 0            | 0 | 0       | 0   |

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Баянтээг багийн Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |     |                 |                |         |     |                                      |     |   |     |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
|  |             |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн            | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Б/21 тоот тушаалаар няравт 1,105.0 мянган төгрөг, нягтлан бодогчид 1,247.2 мянган төгрөгийн 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,352.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.   | 1           | 2,352.0        |               |     | 1               | 2,352.0        |         |     |                                      |     |   |     |
| Санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын шимтгэлд 168.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна   | 1           | 168.2          |               |     | 1               | 168.2          |         |     |                                      |     |   |     |
| Хүүхдийн хоолны материалыг их хэмжээгээр худалдан авч нөөцөлснөөс болж 1,138,570 төгрөгийн хүнсний материал ногоо хадгалах зоорины тог удаан хугацаагаар тасарснаас үүдэн эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон хүнсний ногоог Цэцэрлэгийн Эрхлэгчийн 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/05 тушаалаар акталсан байна. | 1           | 1,138.5        |               |     | 1               | 1,138.5        |         |     |                                      |     |   |     |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>3,659.0</b> |               |     | <b>3</b>        | <b>3,659.0</b> |         |     |                                      |     |   |     |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
| Дүн  |             |     |               |     |                 |     |         |     |
| Нийт дүн   | 0           | 0   | 0             | 0   | 0               | 0   | 0       | 0   |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 | <b>1</b>                |                |       |                            |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 оны 02 дугаар сарын 23